


**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 04 дугаар сарын 07

Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Тахько (ХК) компани Улсын бүртгэлийн дугаар 9010001029 Үнэт цаасны код ТАН-44 Утас/факс: 976-11-324738, 976-11-325051
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	<ul style="list-style-type: none"> <li>• Үл хөдлөх хөрөнгийн түрээс, үйлчилгээ</li> <li>• Гадаад, дотоод худалдаа</li> <li>• Хөрөнгө оруулалт</li> </ul>
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,189,983 ширхэг энгийн хувьцаа
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн Н.Баттуяа, Б.Отгонтөгс Хянасан Д.Минжмаа
1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/-мян.төг	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	<p>Эргэлтийн хөрөнгийн дүн – 4,721,421</p> <p>Эргэлтийн бус хөрөнгийн дүн – 15,954,244</p> <p>Нийт хөрөнгийн дүн – 20,675,666</p> <p>Нийт ер төлбөрийн дүн – 465,358</p> <p>Эздийн өмчийн дүн – 20,210,307</p> <p>Өр төлбөр, эздийн өмчийн дүн – 20,675,666</p>
Орлогын тайлан	<p>Борлуулалтын орлого – 4,041,294</p> <p>Хүүний орлого – 298,453</p> <p>Борлуулалтын өртөг – 1,858,968</p> <p>Ерөнхий удирдлагын зардал – 2,071,377</p> <p>Бусад зардал – 83,677</p> <p>Татварын өмнөх ашиг – 364,305</p> <p>Орлогын албан татвар – 104,187</p> <p>Татварын дараах ашиг – 260,118</p>
Өмчийн өөрчлөлтийн тайлан	<p>Өмч – 199,917</p> <p>Халаасны хувьцаа – (353)</p> <p>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл-13,670,732</p> <p>Хуримтлагдсан ашиг – 6,340,011</p> <p>Нийт эздийн өмчийн дүн – 20,210,307</p>
Мөнгөн гүйлгээний тайлан	<p>Үндсэн үйл ажиллагааны цэвэр МГ- 960,311,3</p> <p>Хөрөнгө оруулалтын ү/а-ны цэвэр МГ – (3,161,365)</p> <p>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр МГ-(116,788)</p> <p>Валютын ханшийн зөрүү – (919)</p> <p>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ – (2,318,761)</p> <p>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл – 2,683,300</p> <p>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл – 364,538</p>

2.	Жилийн эцсийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	Аудитын хороо хэлэлцэхээр хүлээгдэж байгаа	
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Ахиуц цэвэр ашиг = 6.44 Үйл ажиллагааны ахиуц ашиг = 2.9 Хөрөнгө оруулалтын өгөөж = 3.17 Хувьцаат капиталын өгөөж = 1.31 Нийт хөрөнгийн эргэц = 19.43 Өрийн харьцаа = 2.25 Нэгж хувьцааны өгөөж = 219
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа = 16.35 Ажлын цэвэр капитал = 4,432,695 Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа=16.07
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Одоогоор өгөх мэдээлэлгүй байна
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Тайлангийн хугацаанд сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.	

6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
<p>Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм, Монголын компанийн засаглалын кодекс, стандартын шаардлагын зүйл заалтуудыг мөрдөж, засаглалын үйл ажиллагааг ил тод явуулж байгаа болно.</p>		
7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-20.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 9/59, 3/2223, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2023 оны 01/65 тоот бичгээр ирүүлсэн зөвлөмж, шаардлага, үүргийг тус тус хэрэгжүүлж санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийт, холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлэх үүргийг биелүүлж ажилласан.</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолын дагуу "Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр", "Ёс зүйн дүрэм", "Цалин урамшууллын бодлого", "Залгамж халааны бодлого", "Ногдол ашиг олгох журам", "Дотоод аудитын журам", "Дотоод хяналтын журам", "Эрсдэлийн удирдлагын заавар", "Компанийн хяналтын заавар"-уудыг шинээр ба шинэчлэн боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулан мөрдөж ажиллаж байна.</p>		
<p>Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: 2025.04.07</p>		
<p>Овог нэр: Албан тушаал:  Гарын үсэг (тамга/ тэмдэг)</p>	<p>Даваадашийн Минжмаа Тахько (ХК) компанийн Гүйцэтгэх захирал</p> 	<ul style="list-style-type: none"> <li>2024 оны жилийн санхүүгийн тайланд хөндлөнгийн олон улсын аудитыг Солид Юнити аудит ХХК хийсэн.</li> <li>2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав.</li> </ul>
<p>Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2025.04.07</p>		
<p>Овог, нэр: Н.Баттуяа Албан тушаал: Захиргааны асуудал хариуцсан менежер Гарын үсэг: <i>Н. Баттуяа</i></p>		

## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

### НЭГ. КОМПАНИЙН ТУХАЙ

Тахько (ХК) компани Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1992 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 32 дугаар тогтоолоор хувьчлагдах шийдвэр гарч, Тахько хувьцаат компани (100 хувь хувийн өмчид шилжсэн) байгуулагдсан үеэс өнөөдрийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани 1992 онд буюу хувьчлагдах үеийн эхлэлтийн балансаар 345,567.5 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 592,830 ширхэг энгийн хувьцаатай байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 20,628,436.8 мянган төгрөгийн хөрөнгөтэй, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэг бүр нь 168 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийтэд зарласан чөлөөтэй арилжаалагдах 1,189,983 ширхэг энгийн хувьцаатай нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр ажиллаж байна.

### ХОЁР. 2024 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

#### УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

##### Компанийн засаглал

Тахько (ХК) компанийн захиргаа (гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын нэгжийн албадууд) 2024 онд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Монголын компанийн засаглалын кодекс, стандартын шаардлагыг мөрдөж, засаглалын үйл ажиллагааг ил тод явуулж ажилласан.

Компани 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2023 оны санхүүгийн тайланд аудит хийлгэсэн Мүүрү аудит компанийн дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, аудитын компани сонгох зэрэг асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн хийж, хүчин төгөлдөр саналын эрхийн 89.9 хувийн ирцтэйгээр хуралдуулж, хурлаар хэлэлцсэн Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод

ажлын зардлын төсвийг батлах асуудлуудыг хуралд оролцогчдын 95.4-100 хувийн саналын эрхээр тус тус батлуулж шийдвэрлүүлсэн.

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн 6, хараат бус 3 гишүүн сонгогдсон. Сонгогдсон гишүүд өмнө нь компанийн засаглалын сургалтад хамрагдсан, үүнээс хараат бус гишүүд нь Компанийн хуульд заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангаж байгаа бөгөөд сонгогдсон гишүүдийн тухай мэдээллийг Хөрөнгийн биржийн болон компанийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, холбогдох бусад баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК (Арилжаа эрхлэх байгууллага)-д хуульд заасан хугацаанд хүргүүлж, хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан журам, хугацааны заалтыг хэрэгжүүлж ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (ТУЗ-ийн 2024.01.18-ний № 02 тоот тогтоол)-ийн дагуу компанийн 2023 оны цэвэр ашгаас 1,187,883 ширхэг энгийн хувьцаанд хуваарилсан 128,291.4 мянган төгрөгийн ногдол ашгаас хувь хүн ба аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 6,414.7 мянган төгрөг суутган харьяалах татварын байгууллагад шилжүүлэн тайлагнаж, 121,876.7 мянган төгрөг (Үүнээс 116,788.2 мянган төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв компаниар зуучлуулан, 5,088.5 мянган төгрөгийн ногдол ашгийг компани дээр тус тус олгож)-ийн ногдол ашгийг бүртгэлийн өдрөөр ногдол ашиг хүртэх эрхтэй 629 хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр байршуулж, хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тогтоосон хугацаанд тайлагнасан.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-20.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 9/132, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2024 оны 01/39, 01/234 тоот бичгээр ирүүлсэн зөвлөмж, шаардлага, мэдэгдэл үүргийг тус тус хэрэгжүүлж санхүүгийн ба санхүүгийн бус тайлан, хугацаат ба тухай бүр мэдээлэх мэдээллийг хувьцаа эзэмшигч, олон нийт, холбогдох байгууллагуудад тогтоосон хугацаанд мэдээлэх үүргийг биелүүлж ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.7-д заасан үүргийн дагуу Тахько (ХК) компанийн улирлын болон эхний хагас жилийн засаглалын үйл ажиллагааны тайлангуудыг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлж тайлагнасан.

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр,

компанийн бусад мэдээллийг мэдээлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг мэдээллээр хангах үүргийг биелүүлэн ажиллаж байна.

2024 онд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй, үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлөх нөхцөл байдал үүсэж бий болоогүй болно.

Компани 2024 онд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК (Арилжаа эрхлэх байгууллага)-ийн тогтоол, шийдвэр, журмаар тогтоосон нээлттэй хувьцаат компанид холбогдох заалтууд болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажилласан.

Тахько (ХК) компани 2024 онд компанийн засаглалын зарчим, үйл ажиллагааг хэрэгжүүлж Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 12 дугаар зүйлийн 12.1-ийн 12.1.1-12.1.4, 12.2-ын 12.2.1-12.2.4 дэх хэсэгт заасан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны шалгуур (тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргах, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй аудитын байгууллагаар баталгаажуулах, үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний ажлын капиталтай байх эсхүл 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай ажилласан, компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг, компанийн зах зээлийн үнэлгээ, гаргасан үнэт цаасны нийтэд санал болгосон хувь, компани нь засаглалын болон мэдээллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг)-ын дагуу хоёрдугаар ангиллын нээлттэй компанийн шаардлагыг хангаж ажилласан.

### **Компанийн бүтэц, зохион байгуулалт**

Компани нь 2024 онд захиргаа, хүний нөөцийн хэсэг, техник үйлчилгээний хэсэг, санхүүгийн хэсэг, Анкор төв гэсэн бүтэцтэй, 19 орон тоотой ажиллахаар төлөвлөж, 17 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Хөдөлмөрийн хуулийн дагуу ээлжээр ажилласан ажилтнуудад шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс олгож, ажилтнуудыг шөнийн ба илүү цагаар ажилласан тохиолдолд биеэр нөхөж амраадаг болсон.

Компанийн 2024 оны санхүүгийн тайланг "А" форматаар болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-ын дагуу гаргаж, Солид Юнити аудит ХХК-аар олон улсын түвшний аудитын баталгаажуулалт хийлгэж, Төлөөлөн удирдах зөвлөл болон 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулж, дүгнэлт тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн.

Компанийн дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд өмч хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хангамжийн

материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун худалдан авах, хөрөнгийн засвар хийх, үйлчилгээ үзүүлэх зэрэг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 103 гэрээ байгуулж, тэдгээр гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, ажлын үр дүнг хүлээн авч, төлбөр тооцоог хийж дуусгасан.

Компанийн өмч хөрөнгийг эрсдэлээс хамгаалах зорилгоор Практикал даатгал, Миг даатгал, Ард даатгал компаниудтай үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ шинээр байгуулж даатгалын хураамжинд 14,691.8 мянган төгрөг төлсөн.

Гүйцэтгэх захирлын 2024 оны А/17 тоот тушаалаар Ахмадын зөвлөлийн даргаар Ж.Ганхуягийг, гишүүнээр М.Баянжаргалыг томилж ахмадын шинэчилсэн бүртгэлийг хийж, Монголын уламжлалт Сар шинийн баяраар 16, Ахмадын баяраар 22 ахмадуудад хүндэтгэл үзүүлж, мөнгөн урамшуулал олгосон.

Компанийн үр ашгийг дээшлүүлэхэд ажил үйлсээрээ манлайлан, үүрэгт ажилдаа амжилт гарган ажиллаж Монгол Улсын Засгийн газар, Яамны шагналаар шагнагдсан “Онц тээвэрчин”-1, “Санхүү, банкны тэргүүний ажилтан”-1, “Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тэргүүний ажилтан”-3, “Манлай тээвэрчин”-1, нийт 6 ажилтанд шагналын дагалдах 300.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгов.

Анкор төвийг нийгмийн хариуцлагын хүрээнд 2024 оны 5 дугаар сараас 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл Тэнгэр ТВ-д үнэ төлбөргүй түрээслүүлсэн бөгөөд түрээсийн хугацаа дууссаны дараагаас 11 дүгээр сар болон 12 дугаар сард нийт 15 удаагийн 35 цагийн арга хэмжээ үйлчилгээ үзүүлж, 34,845.4 мянган төгрөгийн орлоготой ажилласан. Жилийн дүнгээр Анкор төвийн түрээсийн үйл ажиллагаанд 54,308.9 мянган төгрөг олж төлөвлөгөөг 98.74% биелүүлж ажилласан.

### **Хүний нөөц, нийгмийн хариуцлагын асуудал**

Гүйцэтгэх захирлын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/01 тоот тушаалаар компанийн бүтэц, зохион байгуулалт, албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тоо, цалин хөлсний өөрчлөлтийг шинэчлэн баталж, тайлангийн хугацаанд 17 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, техник, үйлчилгээ хариуцсан инженер 1, цахилгаанчин 2, сантехникийн засварчин 2, ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн нярав, захиргааны асуудал хариуцсан менежер, Анкор төвийн менежер, жолооч зэрэг ажилтныг тус тус шинээр дадлагажуулан ажиллуулав.

Хөдөлмөрийн гэрээгээр тохиролцсон ажлын байрны үндсэн цалингийн хэмжээг мөрдөж, ажлын үр дүнг харгалзан Гүйцэтгэх захирлын 2024 оны А/02 тоот тушаалаар “Цалин хөлсний журам”-ыг баталж, уг журмын хавсралтаар ажлын үр дүнгээр урамшуулал олгох журам, томилолтоор ажиллах журам зэргийг баталж мөрдөн, улиралд нэг удаа үндсэн цалингийн 40 хүртэл хувийн урамшуулал

олгодог байсныг өөрчлөн сарын ажлын үр дүнгээр олгох урамшууллын үндсэн болон харгалзах үзүүлэлтийн жагсаалтыг гарган сар бүр дүгнэх хуудсаар дүгнэн хэлэлцэж сар бүр 15 хувиар олгохоор шинэчилсэн. Ингэснээр ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж, цаг ашиглалт, ажлын хариуцлага, ажилдаа хандах хандлага эрс өөрчлөгдсөн.

Компанийн нийт ажилтнууд (ТУЗ-ын гишүүд орсон)-д 951,323.5 төгрөгийн цалин, хөлс, урамшуулал олгож, цалингийн зардал 2024 онд нийт зардлын 23.55 хувийг эзэлж байна.

Компанийн дотоод үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцаатай холбогдуулан Хөдөлмөрийн дотоод журам, Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам, Дотоод хяналтын (хүнсний) журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний хугацааг тогтоох, захиалга хангамжийн ажлыг зохион байгуулах, хяналт тавих журам, Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт, Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага, Маягт, дэвтрийн загвар Цэвэрлэгээний материал хэрэгслийн жагсаалт, Бичиг хэрэгслийн жагсаалт, Ажил хүлээлцэх, түлхүүр хүлээлцэх журам, Хүнсний Албан хэрэг хөтлөлтийн журмуудыг шинэчлэн боловсруулан баталж, нийт ажилтнуудад танилцуулан мөрдөж хэрэгжүүлж байна.

Хөдөлмөрийн харилцаатай холбоотой, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахаар Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх, акт дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус байнгын ажиллагаатай комисс, Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах байнгын бус комиссыг тус тус байгуулсан.

Үйлдвэрлэлийн осол, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үүднээс Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг ажилд анх ороход, засвар үйлчилгээ хийх тухай бүрд болон өглөө ажил эхлэхэд нийт ажилтнуудад тэр дундаа инженер, техникийн ажилтнуудад танилцуулж, гарын үсэг зуруулах ажил хэвшсэн болно.

Мөн "Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар"-ыг батлан ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, нийт ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ, нууцын гэрээг шинэчлэн байгуулж ажлын байрны тодорхойлолтыг танилцуулж хөдөлмөр зохион байгуулалт, үүрэг чиглэлийг тодорхой болгосон.

Компанийн хэмжээнд мөрдөгдөх албан хэрэг хөтлөлт, санхүүгийн баримт, маягтын загварыг шинэчлэн боловсруулж, компанийн өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Архивын үйл ажиллагааг сайжруулахаар мэргэжлийн байгууллагатай хамтран "Архивын тухай хууль", Хууль зүйн Сайдын 2020 оны 222 дугаар тушаалын дагуу архивын сан хөмрөгт хадгалагдаж байсан 1970-2023 оны



баримтуудад нягтлан шалгалт хийж байнга хадгалах, түр хадгалах, 70 жил хадгалах, зарим нэр төрлийн баримт бичгийг 40 жил хадгалах төрөлд ангилан 1131 баримтад техник боловсруулалт хийж хадгалах нэгж үүсгэн, хугацаа дууссан баримтыг устгах хэрэгт авч, тус бүрт бүртгэл жагсаалт үйлдэн 1994-2023 оны тушаалыг бүрэн скайнердуулж, цахимжуулсан.

Техникийн ажилтнуудад ажлын хувцасны норм, хугацааг шинэчлэн гаргаж, ажлын тусгай хувцас, багаж, хэрэгслийг олгож, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс зайлшгүй байх ажлын тусгай хувцас, багаж, тоног төхөөрөмж хэрэгслийг жагсаалтын дагуу бүрдүүлэн сорилд оруулж дүгнэлт гаргуулан, тусгай шүүгээнд байрлуулан шаардлагатай тохиолдолд ашиглах журмыг боловсруулсан.

Ажилтнуудын ажлын байрны нөхцөлийг сайжруулахаар хөргөгч, буйдангийн бүтээлэг, хоолны тогоог шинэчлэн, ажлын байрны эмх цэгц, ариун цэврийг хангах үүднээс их цэвэрлэгээг тогтмол хийлгэж, цэвэр үзэмжтэй байлгаж хэвшсэн.

Техникийн ажилтнуудын ажил хүлээлцэх дэвтэр, түлхүүр хүлээлцэх дэвтэр, үүрэг даалгаврын дэвтэр, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэр зэргийг тогтмол хэрэглэж хэвшүүлсэн.

Компанийн "Санхүүгийн үйл ажиллагааны сахилга батыг өндөржүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, тэвчиж болох зардлыг хэмнэж ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх тухай", Анкор төвийн үйл ажиллагааг сайжруулахаар "Урамшуулалт аяныг зохион байгуулах тухай", кибер халдлагаас урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагаар "Сахилга, дэг журмыг өндөржүүлэх тухай", "Архивын үйл ажиллагааг сайжруулах тухай", "Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах тухай" зэрэг тушаалыг баталж хэрэгжүүлэн биелэлтийг хангаж ажилласан.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Монголын жижиг хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн холбоонд 7,000.0 мянган төгрөг, Орон нутгийн сонгуулийн сурталчилгаа, үйл ажиллагаанд 20,000.0 мянган төгрөг, Говь-Алтай аймаг, Налайх дүүргийн малчдад өвлийг малын хорогдолгүй өнөтэй давах, өвс тэжээл бэлтгэхэд нь зориулж 15,000.0 мянган төгрөг, Монголын хүүхэд, залуучуудын оюуны хөгжил, боловсрол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжиж үнэ төлбөргүй тараагдах номын хэвлэлтэд зориулж 5,000.0 мянган төгрөг, Говь-Алтай аймгийн нутгийн зөвлөлд өвөлжилтийн бэлтгэл хангах үйл ажиллагаанд 5,000.0 мянган төгрөг, хүйтний эрч чангарч, нүүрсний угаар, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлж ажилтнуудад амны хаалт тараах, хүчилтөрөгчийн эмчилгээнд зориулж 3,300.0 мянган төгрөгийн хандив, тусламжийг үзүүлэв.

Ажилтнуудын амьдралын түвшинг сайжруулахаар 5 ажилтанд 1,800.0 мянган төгрөг, жолооч Б.Болдбаатарыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж 14,000.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус үзүүлэв.

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвд 6 ажилтныг үзлэг, шинжилгээнд хамруулж, үзлэг шинжилгээний оношын дагуу мэргэжлийн эмчийн зөвлөгөө, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авч ажилласан. Мөн "Халиун толгой" эмнэлгийн нэг өрөөг тохижуулан ажилтнууддаа хөнгөлөлттэй эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх тухай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн тохижилт үйлчилгээ, өнгө үзэмж, иргэдийн аюулгүй байдал, цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах зорилгоор Чингэлтэй дүүргийн менежер, Газар зохион байгуулалтын албаны холбогдох албан тушаалтнуудад хүсэлт илгээж өөрийн эзэмшлийн газрын эргэн тойронд байрласан "ТҮЦ" буюу түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хог, хаягдлыг зөв зохистой хаях, хогийн сав, байрны ойр орчныг цэвэр, үзэмжтэй байлгах үүднээс гэрээт аж ахуйн нэгж, байгууллагад хандаж засвар хийлгэсэн. Мөн байгальд ээлтэй байх үйл ажиллагааны хүрээнд гар утас, түүний сэлбэг, зай хураагуур зэргийг ангилан хаях зориулалтын савыг барилгын гадна, дотор талд байрлуулсан.

Ажилтнууд өөрсдийн хүчээр гадна зам талбайг цементлэх, гараашны дотор тал, дээврийн болон хоолойн засварын ажлуудыг хийж гүйцэтгэн, өнгө үзэмжийг сайжруулсан.

Мөн нийт ажилтнуудыг Улаанбаатар-Хөххот-Улаанбаатар, Улаанбаатар-Сайншанд-Чойр-Улаанбаатар маршрутаар танин мэдэхүйн аяллыг зохион байгуулсан.

## **ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ**

### **Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр**

#### **2024 онд хийгдсэн их засварын ажил**

- МА-3 барилгын гаднах автомашины зогсоол, замын асфальт бетонон хучилтын ажлыг Сарт инженеринг энд контракшн ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн АГ/2024-33 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 160,631.0 мянган төгрөгийн зардлаар;
- МА-2 барилгын дээврийн засварын ажлыг Гегатера Тех ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн АГ/2024-35 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 210,500.0 мянган төгрөгийн зардлаар;
- Барилгуудын төв дулааны үзель хүртэл гадна дотор халаалт, цэвэр усны ерөнхий хэвтээ шугам, инженерийн сүлжээний засварын ажлыг Гегатера Тех ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн АГ/2024-32 дугаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 166,994.5 мянган төгрөгийн зардлаар тус тус хийж гүйцэтгэсэн.

#### **Урсгал засварын ажил**

2024 онд гадна гараашийн өнгө сэргээх, зай завсар нүхийг хөөсөөр дүүргэн 74 м<sup>2</sup> талбайд хар замаск татаж тэгшилгээ хийх, 47м<sup>2</sup> таазны талбайд дулаалгын

Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвд 6 ажилтныг үзлэг, шинжилгээнд хамруулж, үзлэг шинжилгээний оношын дагуу мэргэжлийн эмчийн зөвлөгөө, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авч ажилласан. Мөн "Халиун толгой" эмнэлгийн нэг өрөөг тохижуулан ажилтнууддаа хөнгөлөлттэй эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх тухай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн тохижилт үйлчилгээ, өнгө үзэмж, иргэдийн аюулгүй байдал, цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах зорилгоор Чингэлтэй дүүргийн менежер, Газар зохион байгуулалтын албаны холбогдох албан тушаалтнуудад хүсэлт илгээж өөрийн эзэмшлийн газрын эргэн тойронд байрласан "ТҮЦ" буюу түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хог, хаягдлыг зөв зохистой хаях, хогийн сав, байрны ойр орчныг цэвэр, үзэмжтэй байлгах үүднээс гэрээт аж ахуйн нэгж, байгууллагад хандаж засвар хийлгэсэн. Мөн байгальд ээлтэй байх үйл ажиллагааны хүрээнд гар утас, түүний сэлбэг, зай хураагуур зэргийг ангилан хаях зориулалтын савыг барилгын гадна, дотор талд байрлуулсан.

Ажилтнууд өөрсдийн хүчээр гадна зам талбайг цементлэх, гараашны дотор тал, дээврийн болон хоолойн засварын ажлуудыг хийж гүйцэтгэн, өнгө үзэмжийг сайжруулсан.

Мөн нийт ажилтнуудыг Улаанбаатар-Хөххот-Улаанбаатар, Улаанбаатар-Сайншанд-Чойр-Улаанбаатар маршрутаар танин мэдэхүйн аяллыг зохион байгуулсан.

## **ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ**

### **Компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр**

#### **2024 онд хийгдсэн их засварын ажил**

- МА-3 барилгын гаднах автомашины зогсоол, замын асфальт бетонон хучилтын ажлыг Сарт инженеринг энд контракшн ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн АГ/2024-33 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 160,631.0 мянган төгрөгийн зардлаар;
- МА-2 барилгын дээврийн засварын ажлыг Гегатера Тех ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн АГ/2024-35 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 210,500.0 мянган төгрөгийн зардлаар;
- Барилгуудын төв дулааны үзель хүртэл гадна дотор халаалт, цэвэр усны ерөнхий хэвтээ шугам, инженерийн сүлжээний засварын ажлыг Гегатера Тех ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн АГ/2024-32 дугаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 166,994.5 мянган төгрөгийн зардлаар тус тус хийж гүйцэтгэсэн.

#### **Урсгал засварын ажил**

2024 онд гадна гараашийн өнгө сэргээх, зай завсар нүхийг хөөсөөр дүүргэн 74 м<sup>2</sup> талбайд хар замаск татаж тэгшилгээ хийх, 47м<sup>2</sup> таазны талбайд дулаалгын

зөөлөвч хадах, цахилгааны монтажийг сэргээн засварлах зэрэг ажлуудыг хийж нийт 203.5 мянган төгрөг зарцуулсан.

Кабелийн муфьт болон газар шорооны ажилд 2 м<sup>3</sup> хайргаар тэгшилгээ хийн 10 килограммтай 20 ширхэг хүйтэн асфальт дэвсэх ажлуудыг гүйцэтгэж нийт 500.0 мянган төгрөг, хайрга 150.0 мянган төгрөгийн зардал гарсан.

МА1 барилгын нэг давхрын гарах хүзүүвчний урсгал засварыг өөрсдийн хүчээр хийж зөвхөн материалын зардалд 606.7 мянган төгрөг зарцуулсан.

Халаалтын системийн графикт ажлыг 7,775.6 мянган төгрөг, МА-2 барилгын агааржуулалтын системийн үйлчилгээг 2,909.0 мянган төгрөг, Анкор төвийн сантехникийн засварт 208.0 мянган төгрөг тус тус зарцуулсан.

Гадна бохирын худаг угаах ажлыг 2024 оны төлөвлөгөөнд 5,200.0 мянган төгрөг төлөвлөснөөс 2,880.0 мянган төгрөгөөр хийж 2,320.0 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан.

Цэвэр усны тоолуур баталгаажуулалтад 91.1 мянган төгрөгийн зардал гаргасан.

Зам талбайн засвартай холбогдуулан хашааны суурь хэсэгт барилгын өнгө сэргээх заслын ажлыг 2,024.6 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

МА-1 барилгын /Скайтел/ сантехникийн засварт 65.0 мянган төгрөгийн засварын ажлыг гүйцэтгэсэн.

Оффист цэцгийн үйлчилгээнд /шороо авах, савыг солих/ 676.9 мянган төгрөгийн зардал гаргав.

МА-3 барилгын сантехникийн засварт 2,217.0 мянган төгрөг, Дэд өртөөний графикт засварт 5,000.0 мянган төгрөгийн зардал гаргасан.

Графикийн дагуу ялтсан бойлерын угаалга, шахалтын ажилд 4,800.0 мянган төгрөг, U-1 барилгад радиатор солих ажилд 1,440.0 мянган төгрөгийн зардал тус тус гаргасан.

Нийт урсгал засварт 2024 онд барилгад 44,157.2 мянган төгрөг, цахилгаанд 13,038.0 мянган төгрөг, сантехникийн зардалд 17,994.4 мянган төгрөгийг тус тус зарцуулаад байна.

МА1, МА2 барилгыг холбосон хоёр давхрын хүзүүвчийг оффисын зориулалтаар ашиглахаар дотор ханын дулаалга, цонхнуудыг шинээр вакум цонхоор солих, дотор гоёлын хана, шалны дрож угсран, цахилгаан монтажийг шинээр угсарч, разетка, унтраалга туузан гэрэл суурилуулсан нийт зардал 32,000.0 мянган төгрөг болсон бөгөөд ажлыг гүйцэтгэлийн акт үйлдэж фото тайлантай хүлээн авсан.

ХТП-477 дэд өртөөний хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор жил бүр урсгал засварын ажил хийгддэг ба энэ жилийн урсгал засварыг 5,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр Гансеть ХХК-иар хийж гүйцэтгүүлсэн.

Теди /МА-2/ барилгын урд хойд хэсгийн лифтний засвар үйлчилгээ, найдвартай аюулгүй ажиллагааг хангах үүднээс барилгын үндсэн хийцлэлд суусан дамнуурын үл эвдэх сорилын зардалд 3,500.0 мянган төгрөг байснаас 2,100.0 мянган төгрөгөөр нэмэлт хүчитгүүр нэмэх гүйцэтгэлийн зураг гаргуулсан.

Сүлжээний тоног төхөөрөмжийн ажилд нийт 32,490.1 мянган төгрөгийн зардал гарган компанийн сүлжээний жигд, аюулгүй ажиллагааг хангаж ажилласан болно. /программуудын лизенц сунгах, компьютерын үзүүлэлт сайжруулах хард диск, санах ой, дэлгэц авсан/

Худалдан авалтын төлөвлөгөөний дагуу компанид шаардлагатай автомашин техник тоног төхөөрөмж болон бусад шаардлагатай эд зүйлийг худалдан авахад 1,011,665.6 мянган төгрөгийн зардлыг гаргасан болно.

Гүнтийн газар ойр орчныг хянах зорилгоор 360 градусын хяналтын гадаа зориулалттай камер 1ш, техникийн өрөөнд дотор зориулалттай камер 1ш, гурвалжин агуулахын хашаанд гадна зориулалттай камер 1ш тус тус нэмэлтээр суурилуулж 1,205.0 мянган төгрөгийн зардлаар тус тус хийж гүйцэтгэсэн.

### **Хэвийн үйл ажиллагааг хангах бусад ажил**

Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор цахилгаан, дулааны эрчим хүч, усны хэрэглээг хангагч байгууллагуудтай гэрээ байгуулан үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулсан.

2024 онд цахилгаан эрчим хүчний гадаад, дотоод тооцооны нийт 50 гаруй тоолуурын заалтаар цахилгаан эрчим хүчний хэрэглээний тооцоог тогтмол хийж, 351,685.8 мянган төгрөгийн цахилгаан эрчим хүчний үнийг хэрэглэгчдэд хуваарилан төлүүлсэн. Үүнд: цахилгаан 339,662.4 тарифын зөрүү 4,987.5 үйлчилгээний үнэ 8,999.9 мянган төгрөгийг хэрэглэгчид хуваарилж төлбөрийг хийлгэсэн.

Дулааны төлбөрт 70,407.7, үйлчилгээний төлбөрт 2,690.6, цэвэр бохир усны үйлчилгээний төлбөрт 1,095.5, усны төлбөрт 40,469.7 мянган төгрөгийн төлбөрүүдийг хэрэглэгчид хуваарилан төлбөрийг төлүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт, элэгдэл хорогдлын шимтгэл, сэлбэг, аж ахуй, барилга, хангамж, шатах тослох материал, кассын тооцоонд хяналт тавьж, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг бүрэн хийлгэж, өмч хөрөнгийн тооллого хийж, тайлан бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласнаар ямар нэгэн алдаа, зөрчил, дутагдалгүй ажилласан болно.

### **Ажлын байр, ажиллах нөхцөл, аюулгүй байдал, санхүүгийн үйл ажиллагаа**

Ажлын байрны эрүүл, аюулгүй, таатай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 16,928.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (компьютер, дагалдах хэрэгсэл), 3,931.7 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авсан.

Компанийн дотоод сүлжээ 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болох кибер халдлагад өртөж 2023, 2024 оны санхүүгийн бааз устаж, сэргээх боломжгүй байдалд орсон бөгөөд богино хугацаанд санхүүгийн мэдээллийг дахин бүрдүүлж ажилласан.

Цаашид дахин халдлагад өртөхгүй байх, Компанийн оффисын болон мэдээллийн системийн хэвийн сааталгүй ажиллагааг хангах үүднээс Ай Ти аутсорсинг Монголиа ХХК-д гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх шаардлагыг тавьж хамтран ажиллан дотоод сүлжээ, компьютерын болон камерын төхөөрөмж, Nas төхөөрөмж, Unifi controller серверийн өдөр тутмын үйлчилгээг хийлгэн ажиллаж байна. Майкрософт оффис 365, антивирусын программын хугацаа, лицензүүдийг сунгах, домайн нэрийн төлбөр хийх, windows сервер болон компьютерүүдийн үйлдлийн систем, оффисын программуудыг лиценз сунгах, сүлжээнд firewall төхөөрөмж суурилуулж, аж ахуйн агуулахад камер суурилуулан интернэтэд холбож зайнаас хянах, тэдгээрийн найдвартай ажиллагааг хангах зэрэг сүлжээний тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний ажлыг 18,652.9 мянган төгрөгийн зардлаар хийж гүйцэтгүүлсэн.

Мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдал, хяналт тавиулахаар мэргэжлийн компанид хандан гэрээ байгуулсан ажиллаж байгаа.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны хандлага, сэтгэл зүй, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн компани, байгууллага, эрдэмтдийг урьж авчран нийт ажилтнуудад бүтэн өдрийн сургалт, мөн захиргаа болон удирдах ажилтнуудад бизнесийн үндсэн сургалт, хүний нөөцийн сургалт зөвлөгөөнүүдэд давхардсан тоогоор 28 ажилтан хамрагдаж 11,655.0 мянган төгрөг зарцуулсан.

Компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбогдсон санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан болон бусад төрийн байгууллагад тайлагнадаг статистик мэдээ, тайлангуудыг хуульд заасан хугацаанд гаргаж, илгээсэн (тушаасан) болно.

Компани 2024 онд улсын төсөвт 682,588.1 мянган төгрөг төлөхөөс 90.0 хувийг тайлангийн хугацаанд төлж барагдуулсан. Үүнд:

- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татвар 253,201.8 мянган төгрөг
- ✓ Хүүний орлогын албан татвар 23,623.5 мянган төгрөг
- ✓ Хувь хүний орлогын албан татвар 82,676.5 мянган төгрөг
- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл 213,963.2 мянган төгрөг үүнд:
  - Даатгуулагч 84,812.7 мянган төгрөг
  - Ажил олгогч 129,150.5 мянган төгрөг
- ✓ Үл хөдлөх хөрөнгийн татвар 7,509.0 мянган төгрөг
- ✓ Газрын төлбөрт 24,027.1 мянган төгрөг
- ✓ Авто тээврийн өөрөө явах хэрэгслийн албан тавар, агаарын бохирдол болон зам ашигласны төлбөр 842.4 мянган төгрөг
- ✓ Ногдол ашгаас суутгасан татвар 6,146.8 мянган төгрөг
- ✓ Бусад татварт 759,3 бүгд 612,749.6 мянган төгрөг төлсөн.

Компани 2024 онд 4,041,293.7 мянган төгрөгийн орлоготой, 4,039,573.3 мянган төгрөгийн зардалтай, 269,020.0 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, 2023 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад компанийн орлого

799,409.7 мянган төгрөг буюу 22.4 хувиар өсч, зардал 1,206,215.9 мянган төгрөг буюу 44.06 хувиар өсч, хуримтлагдсан ашиг 6,596,432.3 мянган төгрөг болж 4.25 хувиар өссөн байна.

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ АСУУДАЛ  
ХАРИУЦСАН МЕНЕЖЕР

 Н.БАТТУЯА

ХЯНАСАН:  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 Д.МИНЖМАА

